

**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН**

Баян-Өлгий, 2020.12.18

Агуулга

Нэг.Удирдлага зохион байгуулалтын талаар	3-5
Хоёр. Санхүүгийн тайлангийн аудитын талаар	5-10
Гурав. Гүйцэтгэлийн аудитын талаар	10-11
Дөрөв. Нийцлийн аудитын талаар	11-12
Тав. Аймгийн ИТХ-ын хүсэлтээр болон өөрийн санаачилгаар хийсэн аудитын талаар	12
Зургаа. Дотоод ажлын талаар	13-16
6.1. Хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн талаар	13
6.2. Архив-албан хэрэг хөтлөлтийн талаар	13-14
6.3. Мэдээллийн ил тод байдал, олон нийттэй харилцах ажлын талаар	14-15
6.4. Дотоод сургалтын талаар	15
6.5. Ажилдаа нэвтрүүлсэн тэргүүн туршлага, шилдэг арга барил, шинэ санаа.	15-16
6.6. Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд.	16
Долоо. Санхүүгийн тайлагнал, төсвийн гүйцэтгэлийн талаар	17
Найм. Дүгнэлт, санал	18
Ес. Хавсралтууд	18

Товчилсон үгийн тайлбар

ҮАГ	Үндэсний аудитын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
МАН	Монгол ардын нам
АН	Ардчилсан нам
МАХН	Монгол ардын хувьсгалт нам

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2020 оны 12 дугаар сарын 18

Өлгий.

Нэг. Удирдлага зохион байгуулалтын талаар.

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газар нь Монгол Улсын Үндэсний аудитын газраас 2020 оныг “Төрийн аудитын эрх зүйн орчин, стандартын шинэтгэлийн жил” болгон төрийн аудитын байгууллагын хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх чиг үүрэг, үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх бодлого, зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа төлөвлөн, төлөвлөсөн ажлуудаа бүрэн хэрэгжүүлэхэд анхаарлаа хандуулж ажиллалаа.

Аудитын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Монгол Улсын Ерөнхий аудиторын орон нутаг хариуцсан орлогчоор батлуулан, хэрэгжилтийг нь зохион байгуулж ажиллав.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 бүлэг, 60 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилтийг улирал, хагас, бүтэн жилээр зохион байгуулж ажиллав.

Тус газар нь тайлант онд 447.8 сая төгрөгийн батлагдсан төсвөөр, үндсэн 11 орон тоо, гэрээт 1, бүгд 12 орон тоогоор үйл ажиллагаа явууллаа.

Байгууллагын үйл ажиллагааны сарын ажлын мэдээ, хүний нөөцийн мэдээ, төсвийн гүйцэтгэлийн тайлан мэдээг сар бүр, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг улирал, хагас, бүтэн жилээр, статистик мэдээ, үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайланг хагас, бүтэн жилээр гаргаж УАГ-ын холбогдох газруудад хугацаандаа тайлагнаж ажиллав.

Тайлангийн хугацаанд Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжаар 5, өөрсдийн санаачилгаар 7 гүйцэтгэлийн болон нийцлийн аудит, 210 санхүүгийн тайлангийн аудитыг тус тус хийж, төлөвлөсөн аудитыг бүрэн хийж гүйцэтгэв. Аудитад давхардсан тоогоор нийтдээ 72 хүн ажиллаж 1662 хүн өдөр зарцуулж, 2515 цаг илүү ажилласан байна.

Тайлант онд хийсэн аудитын дүнгээр нийтдээ 22415.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, үүнээс 1798.7 сая төгрөгийн алдааг зөрчлийг аудитын явцад залруулж, 59.9 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 14583.4 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага өгч, 4745.2 сая төгрөгийн зөрчил дутагдлыг засаж залруулах 219 заалттай зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.

Аудитын дүнгээр 14 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага, 1 албан тушаалтанд хариуцлага тооцуулах саналыг томилсон эрх бүхий албан тушаалтнуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангуулав.

Аудитын дүнгээр өгсөн зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн актын үр дүнгээр нийтдээ 7990.3 сая төгрөгийн санхүүгийн өгөөжийг бүртгэлд тусгаж, хэрэгжилтийг тооцоолж, холбогдох байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүлж баримтжуулав. Тус газрын 2020 оны төсвийн гүйцэтгэлийн 1 төгрөгт ногдох санхүүгийн үр өгөөж 17 төгрөг 84 мөнгө байна.

Хоёр. Санхүүгийн аудитын талаар.

Төрийн аудитын байгууллагын Төрийн аудитын тухай хууль, Төсвийн тухай хуулиар хүлээсэн чиг үүргийн дагуу төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийх баталгаажуулах аудитыг АДБОУС түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторовн тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам”-ын дагуу хийж гүйцэтгэлээ.

Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2019 оны “Санхүүгийн тайлангийн аудит хийх байгууллагын жагсаалт, аудит хийх хэлбэр батлах тухай” А/60 дугаар тушаалын хавсралтаар баталсны дагуу 155 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 55 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 21 байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүлж өнжөөсөн.

Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2019 оны “Санхүүгийн тайлангийн аудит хийх ерөнхий чиглэл батлах тухай” А/87 дугаар тушаалаар баталсан бодлого чиглэл, аудитын явцад ҮАГ-аас ирүүлсэн чиглэл, зөвлөмжүүдийг тухай бүр хүлээн авч санхүүгийн тайлангийн аудитын ажилд удирдамж, чиглэл болгож, аудиторуудыг тухай бүр мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, зөвлөгөө чиглэл өгч ажиллав.

Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байгууллагуудын аудитын үе шатны ажлуудад чанарын хяналтыг зохих журмын дагуу хэрэгжүүлж, ажлын баримтуудыг цаасаар баримтжуулсны дээр СТАУС программд цахим хэлбэрээр оруулж баримтжууллаа. Санхүүгийн тайлангийн аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг аудит эхлэхээс өмнө хийж батлуулж ажилласны үр дүнд санхүүгийн тайлангийн аудитын ажлыг СТАУС программд цахимаар баримтжуулах ажлыг хугацаанд 100 хувь хийж гүйцэтгэлээ.

Санхүүгийн тайлангийн аудитын ажилд тус газрын 8 аудитор, 3 гэрээт аудитор ажиллаж, нийтдээ 825 хүн өдөр зарцуулж, ажлын шаардлагаар ажлын болон амралт, нийтээр амрах баяр ёслолын өдрүүдэд 2395 илүү цаг ажиллан, 110.6 сая төгрөгийн санхүүгийн нөөц зарцуулжээ.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9 дэх заалтад хамаарах нийт 251 нэгжийн санхүүгийн тайланд аудит хийхээс төсвийн шууд захирагч 134, аж ахуйн нэгж 5, төвлөрүүлэн захирагч 15, ерөнхийлөн захирагч 1, бүгд 155 байгууллагын

санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 55 байгууллага, тусгай сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж гүйцэтгэлээ.

Аудит хийсэн нийт 210 нэгжийн 153-д буюу 72.8 хувьд аудитын газрын аудиторуд, 57-д буюу 27.2 хувьд гэрээт аудиторуд аудит хийлээ. Үндсэн аудиторуд дунджаар 17 байгууллагад, гэрээт аудиторуд 19 байгууллагад аудит хийсэн байна.

Аудитын дүнгээр 143 зөрчилгүй дүгнэлт, 11 хязгаарлалттай дүгнэлт, 1 сөрөг дүгнэлт гаргасан байна. Аудитын дүгнэлтийн 92.3 хувийг зөрчилгүй дүгнэлт, 7.1 хувийг хязгаарлалттай дүгнэлт, 0.6 хувийг сөрөг дүгнэлт эзэлж байна.

Санхүүгийн тайлангийн аудитын дүнгээр нийтдээ 9469.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, үүнээс 1798.7 сая төгрөгийн алдаа зөрчлийг аудитын явцад санхүүгийн тайланд тусгуулан залруулж, 50.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2875.0 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага өгч, 4745.1 сая төгрөгийн алдаа зөрчилд 192 заалт бүхий зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангуулж ажиллав.

Аудитаар илэрсэн нийт алдаа зөрчлийн 66.1 хувь буюу 6256.7 сая төгрөг нь төсвийн шууд захирагчийн, 3.1 хувь буюу 292.7 сая төгрөг нь аж ахуйн нэгжийн, 12.1 хувь буюу 1151.7 сая төгрөг нь төвлөрүүлэн захирагчийн, 18.7 хувь буюу 1768.5 сая төгрөг нь Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаас илэрсэн байна.

Илэрсэн нийт алдаа зөрчлийн 59.3 хувийг нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой, 24.3 хувийг арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй холбоотой, 10.6 хувийг хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой, 4.4 хувийг төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой, 1.4 хувийг бусад алдаа зөрчил эзэлж байна.

Аудитын дүнгээр хязгаарлалттай, сөрөг дүгнэлт авсан байгууллагуудын 14 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг томилсон эрх бүхий албан тушаалтнуудад өгч хэрэгжилтийг хангуулав.

2.1. Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүнгийн талаар.

Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасан хугацаанд санхүүгийн тайлангаа ирүүлэх ёстой нийт 134 байгууллагын санхүүгийн тайланг баталгаажуулж дүгнэлт гаргаж, орон нутгийн 55 байгууллага, тусгай сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан.

Төсвийн шууд захирагчдаас сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Соёлын төв болон Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сан зэрэг батлагдсан төсвийн хэмжээ бага, төсөвт үзүүлэх нөлөө бага байгууллага, нэгжүүдийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж үзлээ.

Аудитын дүнгээр 134 санал дүгнэлт гаргасны 123 нь “зөрчилгүй”, 10 нь “хязгаарлалттай”, 1 нь “сөрөг” дүгнэлт байна. Булган, Буянт, Толбо сумын Засаг даргын тамгын газар, Бугат, Толбо, Сагсай сум, Цагааннуур тосгоны Эрүүл

мэндийн төв, Дэлүүн сумын Сум дундын эмнэлэг, Баяннуур сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургууль зэрэг 10 байгууллагын санхүүгийн тайланд “хязгаарлалттай” санал дүгнэлт, Бугат сумын Засаг даргын тамгын газрын санхүүгийн тайланд “сөрөг” санал дүгнэлт өгсөн байна.

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар нийтдээ 6256.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, үүнээс 1623.7 сая төгрөгийн алдааг залруулж, 50.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2373.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, 2209.2 сая төгрөгийн зөрчлийг засаж залруулах 164 заалт бүхий зөвлөмжийг холбогдох байгууллагуудад өгч хэрэгжилтийг хангуулав.

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангаас илэрсэн алдаа, зөрчлийн талаар товч дурдвал:

Дараах зөрчлүүдэд төлбөрийн акт тогтоосон:

- Ажилчдад олгосон урьдчилгааг дутуу суутгасан, цалингаас суутгасан татвар, дутуу ногдуулсан шимтгэл, харилцагч байгууллагад илүү шилжүүлж санхүүгийн тайланд авлагаар тусгаж харуулаагүй нийт 17.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон.
- Цалингийн санд ногдуулсан нийгмийн даатгалын шимтгэл, суутгасан татварыг санхүүгийн тайланд өглөгөөр тусгаж харуулаагүй 26.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон.
- Илүү олгосон цалин, нэмэгдэл, үр дүнгийн урамшуулал, харилцагч байгууллагад тооцооноос илүү шилжүүлсэн 6.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

Дараах зөрчлүүдийг арилгуулах албан шаардлага, зөвлөмж өгөгдлөө:

- Төсөвт байгууллагууд байр ашиглалттай холбоотой тогтмол зардал болон худалдан авсан бараа материалын нийт 1665.6 сая төгрөгийн тооцоог өглөгийн дансанд бүртгэж, тооцоо үүсгэхгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан.
- Ерөнхий боловсролын сургуулиуд дотуур байрны хүүхдийн нэг өдрийн хоолны зардлын нормыг 115.3 сая төгрөгөөр, цэцэрлэгүүд хүүхдийн нэг өдрийн хоолны зардлын нормыг 8.0 сая төгрөгөөр жилийн дүнгээр хэтрүүлэн зарцуулсан.
- Төсөвт байгууллагууд нийт 316.2 сая төгрөгийн бараа материал, шатахууны тооцоо, хөрөнгийн тооллого тооцоог зохих журмаар хийгээгүй, 68.1 сая төгрөгийн хөрөнгийг бүрдэл дутуу баримтаар зарцуулсан.
- Мөн төсөвт байгууллагууд нийт 980.5 сая төгрөгийн авлагыг зөрүүтэй тайлагнаж, Сум хөгжүүлэх сангийн жилийн эцсийн авлагыг баталгаажуулаагүй, авлага, өр төлбөр 1319.7 сая төгрөгөөр нэмэгдсэн.
- Төсөвт байгууллагууд нийт 1923.3 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой алдаа зөрчил гаргасан.
- Орон нутгийн харьяа нийт байгууллагын 85.0 хувь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж батлуулан мөрдөж ажиллаагүй байна.

- Төсөвт байгууллагууд нийт 56.2 сая төгрөгийг төсвийн зардлын бүлэг хооронд зөвшөөрөлгүй шилжүүлэн зарцуулж, 141.7 сая төгрөгийг үр ашиггүй зарцуулсан.
- Нийгмийн халамжийн сангийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр худалдан авсан 44.0 сая төгрөгийн компьютер, тоног төхөөрөмж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөр худалдан авсан 16.5 сая төгрөгийн программ хангамж, тоног төхөөрөмж, сандлыг Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын данс бүртгэлд орлого аваагүй.
- Асрамжийн газар Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2016 онд баригдсан 170.0 сая төгрөгийн өртөг бүхий дуусаагүй барилгыг үндсэн хөрөнгийн дусаагүй барилга дансанд бүртгэж, санхүүгийн тайланд тусгаж тайлагнаагүй.

2.2. Төрийн болон орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар

Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасан хугацаанд санхүүгийн тайлангаа ирүүлэх ёстой төрийн болон орон нутгийн өмчийн Цахилгаан шугам сүлжээний газар, “Суат” ХХК, “Хала өркени”, “Жана өлке” ОНӨААТҮГ, Онгоцны буудал зэрэг 5 аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланг баталгаажуулж, “зөрчилгүй” дүгнэлт гаргав.

Аудитын дүнгээр орон нутгийн өмчийн хоёр аж ахуйн нэгжид авлагыг барагдуулах, авлага, өр төлбөрийг тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулж, санхүүгийн тайланд үнэн зөв тусгаж байх талаар 3 заалттай зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтийг хангуулав.

2.3. Төсвийн төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар

Төсвийн тухай хуулийн 8.9.2, 8.9.3-т заасан хугацаанд санхүүгийн тайлангаа ирүүлэх 14 сумын болон Нийгмийн даатгалын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд дүгнэлт гаргав.

Аудитын дүнгээр 14 төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд “зөрчилгүй”, Бугат сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд “хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар нийтдээ 1151.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, үүнээс 175.0 сая төгрөгийн алдаа зөрчлийг залруулж, 246.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, 729.9 сая төгрөгийн зөрчлийг засаж залруулах, хэрэгжүүлж ажиллах талаар 19 заалт бүхий зөвлөмж өгч хэрэгжилтийг хангуулав.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн илэрсэн алдаа, зөрчлийн талаар товч дурдвал:

- Бугат, Буянт, Цэнгэл, Өлгий сумын Сум хөгжүүлэх сангийн жилийн эцсийн зээлийн авлагын үлдэгдлийг тооцоо хийж баталгаажуулаагүй.

- Өлгий сумын Сум хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн авлагын тооцоо, бүртгэл хөтлөлт хангалтгүй, санхүүгийн тайланд тусгасан авлагын үлдэгдэл, жилийн эцсийн мэдээнээс 41.7 сая төгрөгөөр зөрүүтэй, Алтанцөгц сумын Сум хөгжүүлэх сангийн санхүүгийн тайлан дахь зээлийн авлагын үлдэгдэл авлагын жагсаалтаас 3.7 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан.
- Бугат сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар танилцуулга, орон нутгийн төсвийн орлогын тооцоо, тайлан, бусад нэмэлт судалгаа болон Эргэлтийн эмийн сангийн тайлан, санхүүгийн баримтыг аудитад ирүүлээгүй, санхүүгийн нэгтгэсэн тайланг хуульд заасан хугацаанаас хожимдуулж ирүүлсэн.

2.4. Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, аймгийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүнгийн талаар.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, аймгийн Нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хуулийн хугацаанд аудит хийж, “зөрчилгүй” дүгнэлт гаргалаа.

Аудитын дүнгээр нийтдээ 1768.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, үүнээс 255.2 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага өгч, 1513.3 сая төгрөгийн зөрчлийг засаж залруулах 6 заалт бүхий зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад өгч хэрэгжилтийг хангуулав.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаас 1554.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, 60.3 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага, 1494.6 сая төгрөгийн зөрчлийг засаж залруулах зөвлөмж өгсөн.

Аймгийн Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангаас 213.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, 194.9 сая төгрөгийн зөрчилд арилгуулах албан шаардлага, 18.7 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

Аудитаар илэрсэн алдаа зөрчлүүдийг хураангуйлан харуулбал:

- Тусгай зориулалтын шилжүүлгийн төсөвт байгууллагуудын авлага оны эцэст 610.5 сая төгрөгт хүрч, авлага оны эхнээс 499.0 сая төгрөгөөр нэмэгдсэн.
- Төсвийн шууд захирагчид оны эцэст 820.7 сая төгрөгийн өглөгтэй гарч, оны эхнээс 69.6 сая төгрөгөөр буурсан боловч зарим байгууллагуудын өглөг нэмэгдсэн.
- Шүүхийн шийдвэрээр ажлаас үндэслэлгүй халагдсан нь тогтоогдож ажилдаа эргэн томилогдсон төсөвт байгууллагад ажилладаг 16 хүний ажилгүй байсан хугацааны цалинд төсвөөс нийт 60.3 сая төгрөгийг шүүхийн шийдвэрийг үндэслэн олгосон.

Аудитын дүнгээр Санхүүгийн хяналт, аудитын албад Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1, 103.2 дахь заалтын дагуу шүүхийн шийдвэрээр ажилдаа эргэн томилогдсон иргэдийн хохирлыг барагдуулсны улмаас төрд

учирсан 60.3 сая төгрөгийн хохирлыг төлүүлэх арга хэмжээ авч зөрчлийг арилгуулах албан шаардлага өгсөн.

Аймгийн Засаг даргад авлага, өр төлбөрийг барагдуулах, Аймгийн ИТХ-аас баталсан төлөвлөгөөг Засгийн газрын Э-тайланд зөрүүгүй оруулж тайлагнах, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналд тавих хяналтыг сайжруулах, төсөвт байгууллагуудын цалин, нийгмийн даатгалын шимтгэл, халаалтын зардлын төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг үндэслэлтэй хийх, аймгийн ИТХ-д өргөн мэдүүлсэн төсвийн төслийн хавсралт тооцооллуудыг нягталж, зөрүүгүй оруулж байх, Сумуудын ИТХ-д Сум хөгжүүлэх сангийн төсвийн зарлагыг зээлийн эргэн төлөлтийн тухайн оны боломжит хэмжээтэй уялдуулан үндэслэлтэй төлөвлөх талаар чиглэл өгч ажиллах зэрэг 6 заалт бүхий зөвлөмж хүргүүлж, биелэлтийг авч баримтжуулав.

Аймгийн Орон нутгийн 2021 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх ажлын талаар.

Аймгийн Засаг даргаас аймгийн ИТХ-д өргөн мэдүүлсэн аймгийн 2021 оны төсвийн төсөлд Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т заасны дагуу аймаг дахь Төрийн аудитын газар дүгнэлт гаргалаа.

Сангийн яамнаас Баян-Өлгий аймгийн 2021 оны нэгдсэн төсвийн нийт орлогыг 90863.1 сая төгрөгөөр, нийт зарлагын хэмжээг 90812.9 сая төгрөгөөр хянаж ирүүлсэн байна.

Төсвийн орлогын 11206.4 сая төгрөгийг орон нутгийн татварын орлогоос, 5740.5 сая төгрөгийг санхүүгийн дэмжлэгээр, 65443.3 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр, 513.0 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 7959.8 сая төгрөгийг ОНХНС-гийн орлогын шилжүүлгээс бүрдүүлэхээр тусгажээ. Төсвийн нийт зарлагын 16896.8 сая төгрөгийг суурь зарлага, 65956.3 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлэг, 7959.8 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн зарлага эзэлж байна. Аймгийн 2021 оны төсвийн төсөл, 2020 оны хүлээгдэж буй гүйцэтгэлд хийсэн дүн шинжилгээнд үндэслэн аудитаар дараах дүгнэлтийг гаргав.

Төсвийн орлогын хувьд: Ковид-19 цар тахлын улмаас гадаадын жуулчдаас ордог ан амьтны нөөц ашигласны төлбөр, хураамжийн орлогод төлөвлөсөн 650.0 сая төгрөгийн орлого тасрах эрсдэл өндөр байгааг харгалзан энэхүү орлогоос бүрдүүлдэг байсан эх үүсвэрийг бусад төрлийн орлогуудаас нөхөх замаар төсвийн орлогын эх үүсвэрийн дутагдал гаргахгүй ажиллах шаардлагатай болсон байна. Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвараас орох орлогын төлөвлөгөөг 250.0 сая төгрөгөөр, Хөрөнгийн орлогыг 120.0 сая төгрөгөөр, Үл хөдлөх хөрөнгийн албан татварыг 25.0 сая төгрөгөөр, Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн татварыг 40.0 сая төгрөгөөр, нийтдээ 435.0 сая төгрөгөөр орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх, Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөг бууруулж батлах.

Төсвийн зарлагын хувьд: Орон нутгийн суурь зарлагыг Сангийн яамнаас хянаж ирүүлсэн төсвөөс 1105.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн. Албан томилолтын зардлыг 20.8 сая төгрөгөөр, тээвэр шатахууны зардлыг 20.4 сая

төгрөгөөр, нийтдээ 41.2 сая төгрөгөөр төсвийн суурь зарлагыг бууруулах. Орон тоо, цалингийн тооцоог цалингийн нэгдсэн системд бүрэн оруулж, төсвийн үргүй зардлыг бууруулах, орон тооны хязгаарыг мөрдөж ажиллах, Сумын Соёлын төвүүдийн халаалтын зардалд шаардагдах хөрөнгийг 2021 оны төсвийн төсөлд тооцож тусгах, халаалтын зардлыг тооцоо судалгаанд үндэслэн, өр төлбөр гаргахгүй байхаар оновчтой, үндэслэлтэй хийж төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээний жагсаалтад ТЭЗҮ, зураг төсөв нь хийгдээгүй төсөл арга хэмжээг оруулж Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ыг мөрдөөгүй байна.

Тусгай зориулалтын шилжүүлгийн төсвийн хувьд: Ерөнхий боловсролын сургуулиудад жишиг орон тоонд байхгүй номын санчийн туслах, дотуур байрны нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, статистик мэдээ хариуцсан ажилтан зэрэг шаардлагагүй орон тоонуудыг төсөвт тусгаж батлахгүй байх, СӨБ-ын байгууллагуудад сантехникч, гал тогооны туслах, эмч, бэлтгэгч, биеийн тамирын багш, жижүүр зэрэг бусад цэцэрлэгүүдэд байхгүй, шаардлагагүй орон тоонуудыг төсөв тусгаж батлахгүй байх, үүнд ногдох цалин, НДШ-ийн зардлыг бусад хүрэлцэхгүй байгаа зардалд хуваарилж төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх, Ерөнхий боловсролын сургуулиудын 2021 оны орон тооны хязгаарыг аймгийн Засаг даргын захирамжаар баталсан ЕБС-иудын бүтэц орон тоотой тулган баталгаажуулах, Орон тоо, цалингийн тооцоог цалингийн нэгдсэн системд бүрэн оруулж, төсвийн үргүй зардлыг бууруулах, орон тооны хязгаарыг мөрдөх,

Сумын эрүүл мэндийн төвүүдэд стандартын дагуу байвал зохих зайлшгүй шаардлагатай батлагдсан орон тоонд ороогүй, ажиллаж байгаа орон тоог орон тооны хязгаарт нэмж тусгах, Аймгийн Эрүүл мэндийн газрын даргын орон тооны үлгэрчилсэн загварыг мөрдөж, тэтгэвэрт гарах хүний орон тоонд зайлшгүй шаардлагатай биш бол хүн авахгүй байж илүү орон тоог нөхөж ажиллах, Эрүүл мэндийн төвүүдийн бараа үйлчилгээний бусад зардлыг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж хуваарилж тэвчиж болох зардлуудыг бууруулж, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх шаардлагатай байна. Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны хоолны зардал, үдийн цайны зардал, Хүүхдийн цэцэрлэгүүдийн хоолны зардлыг аймгийн Боловсрол соёл урлагийн газрын статистик мэдээг үндэслэн батлагдсан норм нормативын дагуу тооцсон байна.

Төсвийн төсөлд өгсөн дүгнэлтийн хэрэгжсэн дүнгээр орон нутгийн төсвийн орлогыг 435.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн, суурь зарлагыг 41.2 сая төгрөгөөр бууруулсан, нийт дүнгээр 476.2 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөжийг бүртгэж, тооцож баримтжуулав.

Гурав. Гүйцэтгэлийн аудитын талаар.

Тайлант онд Үндэсний аудитын газрын аудитын нэгдсэн удирдамжаар 3, өөрсдийн санаачилгаар 4, бүгд 7 сэдвээр гүйцэтгэлийн аудит хийж гүйцэтгэлээ. Гүйцэтгэлийн аудитад давхардсан тоогоор 17 хүн 375 хүн өдөр ажиллаж, 90.9 сая төгрөгийн санхүүгийн нөөц зарцуулсан байна.

Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжаар Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2019 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, Сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэл, Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүнд тус тус гүйцэтгэлийн аудит хийж, аудитын тайланг Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан, холбогдох судалгаа мэдээллийн хамт Үндэсний аудитын газарт хугацаанд нь хүргүүллээ.

Тайлант онд хийсэн гүйцэтгэлийн аудитын дүнгээр нийтдээ 6423.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, үүнээс 1.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 6424.8 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага, 16 заалттай зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2019 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж бий болсон 3596.4 сая төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагууд данс бүртгэлд орлогод аваагүй байсан зөрчилд албан шаардлага өгч орлого авхуулж, Газрын болон тендерийн маргаанаас болж хөрөнгө оруулалтын ажил хугацаандаа хэрэгжихгүй байгаа явдалд дүгнэлт хийж, хөрөнгө оруулалтын ажлыг хугацаанд нь гүйцэтгүүлэх боломж бүрдүүлэх, Барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын бүрэлдэхүүнийг хууль журамд заасны дагуу томилж байх, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүдийн ажлын төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилттэй холбогдолтой баримт материалыг архивын хуулийн дагуу бүрдүүлж баримтжуулан хадгалах, Тендерийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаанд хууль, журмыг мөрдөж, маргаан гаргахгүй ажиллах талаар зөвлөмж өгч хэрэгжилтийг хангуулав.

- Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүнд хийсэн аудитад аймгийн ерөнхий боловсролын 19 сургууль, Боловсрол, соёл урлагийн газар, Мэргэжлийн хяналийн газрын үйл ажиллагааг хамруулан шалгав.

Аудитын дүнгээр боловсролын салбарт тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэх, сургалтын чанарыг сайжруулахад чиглэгдсэн зөвлөмжүүд өгөгдлөө. Үүнд: Аймгийн Засаг даргад: -Ерөнхий боловсролын сургуулиудын хичээлийн байрны нөхцөл байдалд нэгдсэн судалгаа, дүн шинжилгээ хийж зориулалтын бус хичээлийн байртай сургуулиудад хичээлийн байр барих, насжилт нь өндөр хуучирсан хичээлийн байртай сургуулиудыг их засварт оруулах ажлыг аймгийн хөгжлийн бодлоготой уялдуулан төлөвлөх, Аймгийн ИТХ-ын 2014 оны 51 дүгээр тогтоолоор баталсан “Хос хэлээр сургалт явуулдаг сургуулийн сургалтын талаар баримтлах бодлого чиглэл”, 2017 оны 30 дугаар хуралдааны тогтоолоор баталсан “Элсэлтийн ерөнхий шалгалтын үр дүнг дээшлүүлэх”, “Бага боловсрол, эх хэл, монгол хэлний сургалтын чанарыг сайжруулах” аймгийн дэд хөтөлбөрүүдийн биелэлтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж, биелэлтийг хангуулахад анхаарч ажиллах, Ерөнхий боловсролын орон нутгийн төсвөөс олгох тогтмол зардлын төсвийг холбогдох эрх зүйн акт, нормативыг үндэслэн бодит тооцооллын үндсэн дээр төлөвлөж, хуваарилах.

Аймгийн Боловсрол, соёл урлагийн газарт: -Сургалтын чанарт сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлүүдийг бодитой тодорхойлж, эрсдэлийг бууруулах тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх, Ерөнхий боловсролын сургууль, багш нарыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, зөвлөн туслах чиг үүргийг үр нөлөөтэй хэрэгжүүлж, сургуулийн үйл ажиллагаанд хийх хяналт, шалгалтыг үр дүнтэй зохион байгуулж, үр дүнг хугацаандаа тооцож ажиллах, Хос хэлээр сургалт явуулах сургуульд мөрдөх сургалтын төлөвлөгөө, хос хэлний сургалттай сургуулийн казах, тува хэл, уран зохиолын боловсролын стандартыг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулах, Боловсролын стандарт, хөтөлбөр, төлөвлөгөөнд нийцсэн албан ёсны сурах бичгээр үндэсний цөөнхийн хүүхдүүдийг хангах, Жилийн эцсийн бага боловсролын монгол хэлний стандартын хэрэгжилтийг шалгах улсын шалгалтын сэдвийг тусгайлан боловсруулах талаар зөвлөмжүүд өгөгдлөө.

Дөрөв. Нийцлийн аудитын талаар.

Тайлант онд Үндэсний аудитын газрын аудитын нэгдсэн удирдамжаар 2, өөрсдийн санаачилгаар 3, бүгд 5 сэдвээр нийцлийн аудит хийж гүйцэтгэлээ. Нийцлийн аудитад давхардсан тоогоор 12 хүн 412 хүн өдөр ажиллаж, 99.3 сая төгрөгийн санхүүгийн нөөц зарцуулсан байна.

Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны хөрөнгийн зарцуулалт, үр дүнд нийцлийн аудит хийж дүнг баталгаажуулан, аудитын тайланг судалгаа мэдээний хамт Нийцлийн аудитын газарт хугацаанд хүргүүллээ.

- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар 142 байгууллагын шилэн дансны хэрэгжилтийг хамруулан шалгахад хуулийн хэрэгжилт аймгийн дүнгээр 82.8 хувьтай гарсан байна. Аудитын дүнгээр Санхүүгийн хяналт аудитын албад хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллах талаар 2 зөвлөмж хүргүүлж, биелэлтийг авсан.

- Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны хөрөнгийн зарцуулалтад хийсэн нийцлийн аудитаар 6522.3 сая төгрөгийн зөрчил илэрч үүнээс 7.7 сая төгрөгийн зөрчилд акт тогтоож, 5286.6 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага, 9 заалттай зөвлөмж өгч 1228.0 сая төгрөгийн 2 асуудлыг хуулийн байгууллагад шилжүүлэн шалгуулах саналаа Монгол улсын Ерөнхий аудитор хүргүүллээ.

Аудитаар өмнөх хоёр жилд хийсэн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг давтан шалгахад иргэдийн санал аваагүй төсөл, арга хэмжээг жагсаалтад оруулж батлуулж хэрэгжүүлсэн, сангийн хөрөнгийг зориулалт бус зарцуулсан, үр өгөөж багатай төсөл, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн, ОНХС-гийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг данс бүртгэлд орлого аваагүй зэрэг зөрчлүүд давтагдан гарч аймгийн ОНХС-тай холбоотой 2725.5 сая төгрөгийн, сумуудын ОНХС-тай холбоотой 2561.1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөгдлөө. Мөн аймгийн ИТХ, Засаг даргад ОНХС-гийн төлөвлөлт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх талаар зөвлөмжүүд өгөгдлөө.

**Тав. Аймгийн ИТХ-ын хүсэлтээр болон өөрийн санаачилгаар
хийсэн аудитын талаар.**

Тус газрын 2020 оны төлөвлөгөөнд аймгийн ИТХ-аас аудит хийлгэх санал ирүүлээгүй болно. Тайлант онд өөрсдийн санаачилгаар гүйцэтгэлийн 4, нийцлийн 3 аудит хийлээ. Өөрсдийн санаачилгаар хийгдсэн гүйцэтгэлийн аудитад давхардсан тоогоор 10 хүн ажиллаж 249 хүн өдөр зарцуулав. Нийцлийн аудитад давхардсан тоогоор 15 хүн ажиллаж 196 хүн өдөр зарцуулав.

Үүнд Сум хөгжүүлэх сангийн зарцуулалтад хийгдсэн аудитын мөрөөр хийсэн ажлын үр дүнг давтан шалгах, аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2018-2019 оны үйл ажиллагаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2017-2019 оны үйл ажиллагаа, Аймаг, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд тус тус гүйцэтгэлийн аудит хийж, аудитын тайланг Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан, холбогдох байгууллагуудад хүргүүлэв. Иргэдийн өргөдлийн мөрөөр 3 байгууллагад аудит хийлээ.

Гүйцэтгэлийн аудитын дүнгээр нийтдээ 2784.2 сая төгрөгийн зөрчил илэрч, үүнээс 0.7 сая төгрөгийн зөрчилд акт тогтоож, 2783.5 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах, дотоод хяналтыг сайжруулахад чиглэгдсэн 4 зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Аудитын дүнгээр нэг албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлж биелэлтийг хангуулан, 94.4 сая төгрөгийн зөрчлийг хуулийн байгууллагаар шалгуулахаар шилжүүлэв.

- Сум хөгжүүлэх сангийн зарцуулалтад 2018 онд хийгдсэн аудитын мөрөөр хийсэн ажлын үр дүнг давтан шалгах гүйцэтгэлийн аудитад 14 сумын Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг хамруулан, өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг давтан шалгаж, аудитын тайланг 13 сумын Засаг дарга болон аймгийн ХХААГ-т хүргүүлэв.

Аудитын дүнгээр хугацаа хэтэрсэн зээлийн эргэн төлөлтийг үр дүнтэй хэрэгжүүлээгүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй зэрэг зөрчлүүд илэрч, 12 сумын Засаг даргад 2326.7 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага өгөв. Мөн аймгийн ХХААГ-т сумуудын Сум хөгжүүлэх сангийн программыг үр дүнтэй ашиглах талаар мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, сангийн зээлийн мэдээллийг Монгол банкны мэдээллийн санд холбох ажлыг шуурхай зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллах, Сангийн тайланг хүлээж авахдаа зээлийн үлдэгдлийг анхан шатны баримт, зээлийн авлагын бүртгэлтэй тулган баталгаажуулж, мэдээ тайлангийн үнэн зөв байдлыг хангаж ажиллах талаар 2 заалттай зөвлөмж өгөв.

Зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, 678.9 сая төгрөгийн албан шаардлагыг хангуулж, хугацаа болоогүй 1647.8 сая төгрөгийн албан шаардлага дараа онд шилжив. Өмнөх онд хийсэн зөвлөмж, албан шаардлагын дүнгээр 707.6 сая төгрөгийн үр өгөөжийг бүртгэж, тооцоолон баримтжуулав.

- Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2018-2019 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын дүнгээр зөрчлийн хэрэг, зөрчлийн хэргийн хялбаршуулсан журмын харилцахын орлогын бүртгэл тооцоо хангалтгүй, 2019 оны тайлан тооцоогоор 63068 тоот зөрчлийн хэргээр үүссэн 211.3 сая төгрөгийн торгуулийн авлагыг холбогдох шийдвэргүйгээр барагдуулснаар тайлагнасан, төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 1.1 сая төгрөгийн бараа материалыг орлогод аваагүй, байр ашиглахтай холбоотой гарсан 40.0 сая төгрөгийн тогтмол зардлыг өглөгийн тооцоо үүсгэлгүй шууд зардлаар тайлагнасан 252.4 сая төгрөгийн зөрчил илэрч зөрчил арилгуулах албан шаардлага, 2 заалттай зөвлөмж өгч хэрэгжилтийг хангуулав.

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын үйл ажиллагаанд хийсэн аудитаар 2017-2019 оны үйл ажиллагааг хамруулан шалгаж аудитын дүнгээр нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой 100.5 сая төгрөгийн зөрчил илэрч, зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв. Албан шаардлагын хэрэгжих хугацаа болоогүй байна.

Аудитаар Захиргааны ерөнхий хуулийн 103.2, Төрийн аудитын тухай хуулийн 36.1 дэх заалтуудыг хэрэгжүүлэхтэй холбоотой төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагаанаас төрд учирсан хохирлын судалгааг 2017-2020 оныг хамруулан хийж, давхардсан тоогоор 102 хүнтэй холбоотой 427.3 сая төгрөгийн судалгааг гаргаж нотлох баримтыг нь баримтжуулах ажил хийгдлээ. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын үдсэн баримт материалаас шүүхийн шийдвэрийг авах боломжгүй байсан тул аймгийн Шүүхийн тамгын газарт шүүхийн шийдвэрийн хуулбарыг авахаар албан бичиг хүргүүлж нотлох баримтуудыг гаргуулан авсан болно.

Мөн өөрсдийн санаачилгаар Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөгчдийн сонгуулийн хуулийн 37.10, 37.11, 37.12, 49.1-д заасны дагуу “Аймаг, сумын орон нутгийн сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох”, “Аймаг, сумын ИТХ-ын сонгуульд оролцох нам, эвслийн хандивын тайланд дүгнэлт гаргах”, “Орон нутгийн 2020 оны ээлжит сонгуульд оролцох улс төрийн нам эвсэл, бие даан нэр дэвшигчдийн сонгуулийн мөрийн хөтөлбөр, эдийн засгийн тооцоо судалгаанд дүгнэлт гаргах” сэдвээр тус тус нийцлийн аудит хийлээ.

- Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуулийн 49.1-д заасны дагуу 2020 оны аймаг, сумын ИТХ-ын сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох ажил хуулийн хугацаанд төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийгдлээ. Үүнд аймгийн ИТХ-ын сонгуульд оролцох нам, эвслээс зарцуулах зардлын дээд хэмжээг 419.2 сая төгрөгөөр, аймгийн ИТХ-ын сонгуульд оролцох нэр дэвшигчийн зардлын дээд хэмжээг 10.0-55.0 сая төгрөгөөр, сумын ИТХ-ын сонгуульд оролцох нам, эвслээс зарцуулах зардлын дээд хэмжээг 2.7-61.1 сая төгрөгөөр, сумын ИТХ-д оролцох нэр дэвшигчийн зардлын дээд хэмжээг 2.6-17.3 сая төгрөгөөр газар нутгийн хэмжээ, сонгогчийн тоо г.м үзүүлэлтүүдийг харгалзан тогтоож, тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулав. Зардлын дээд хэмжээ тогтоосон шийдвэрийг Аймгийн Сонгуулийн хороонд хуулийн хугацаанд хүргүүлж, ҮАГ-ын вэб сайтад байршуулан, сонгуульд оролцох намуудад хүргүүлсэн.

- Аймаг, сумын ИТХ-ын сонгуульд оролцох 8 нам хандивын тайлангаа хуулийн хугацаанд ирүүлсэн. Аудитаар аймаг, сумын ИТХ-ын ээлжит сонгуульд оролцох аймгийн МАН, АН, МАХН, Хөдөлмөрийн үндэсний нам, Шударга иргэдийн нэгдсэн эвсэл нам, Хөгжлийн хөтөлбөр нам, Иргэний хөдөлгөөний нам, Монголын Ногоон намын ирүүлсэн хандивын тайланг Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хууль, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/47 тоот тушаалаар батлагдсан зааврыг баримтлан Улс төрийн намын тухай хуулийн 18 дугаар зүйлтэй нийцэж буй эсэхийг дэмжих нотлох баримт, дүн дүгнэлтийн үндсэн дээр хянан баталгаажуулж, дүгнэлт гаргав.

Монголын Ногоон нам орон нутгийн сонгуульд оролцохгүй болсон тул сонгуулийн мөрийн хөтөлбөр, хандивын тайланг буцаан авах хүсэлт ирүүлсний дагуу дүгнэлт гаргаагүй, ирүүлсэн хандивын тайланг нь буцаан хүргүүлсэн. Хандивын тайлан өгсөн дүгнэлтүүдийг ҮАГ-ын вэб сайтад байршуулсан.

- Орон нутгийн 2020 оны ээлжит сонгуульд оролцох улс төрийн нам эвсэл, бие даан нэр дэвшигчдийн сонгуулийн мөрийн хөтөлбөр, эдийн засгийн тооцоо судалгаанд дүгнэлт гаргах аудит хуульд заасан хугацаанд төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу хийгдлээ.

Аймаг, сумын ИТХ-ын сонгуульд оролцох 8 нам, 2 намын сумууд дахь салбар болон 19 бие даан нэр дэвшигч сонгуулийн мөрийн хөтөлбөрөө хуулийн хугацаанд ирүүлснийг бүртгэж хүлээн авсан. Аудитын дүнгээр аймаг, сумын ИТХ-д нэр дэвших 8 нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд заасан шаардлага хангаагүй талаар дүгнэлт гаргаж буцааж, мөрийн хөтөлбөрийн хологдох заалтуудыг нь засуулж авч дүгнэлт гаргалаа. 1 нам мөрийн хөтөлбөрөө буцааж авах хүсэлт ирүүлсний дагуу буцааж 7 нам, 2 намын сумууд дахь салбар болон 19 бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргаж хуулийн хугацаанд хүргүүлэв. Нам, бие даан нэр дэвшигчдийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт гаргасан аудитын дүгнэлтүүдийг ҮАГ-ын вэб сайтад байршуулсан.

- Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хуралд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх аудит үргэлжлэн хийгдэж байгаа бөгөөд хуулийн хугацаанд буюу 2021 оны 1 дүгээр сарын 15-ны дотор аудитын дүнг нэгтгэж гаргана.

Зургаа. Зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын бүртгэл, тайлагналын талаар

Тайлангийн хугацаанд өмнөх оноос шилжиж ирсэн 18 зөвлөмж, 96.8 сая төгрөгийн төлбөрийн акт, 429.5 сая төгрөгийн албан шаардлагыг статистик мэдээнд шилжүүлэн бүртгэж, тайлант онд хийсэн аудитаар өгсөн 219 зөвлөмж, 59.9 сая төгрөгийн төлбөрийн акт, 14583.4 сая төгрөгийн албан шаардлагыг статистик мэдээнд тусган бүртгэж, хэрэгжилтийг тооцож тайлагнаж байна.

6.1. Зөвлөмжийн биелэлт:

Өмнөх оноос шилжиж ирсэн 18, тайлант онд өгсөн 219, бүгд 237 зөвлөмжийг статистик мэдээний бүртгэлд тусгаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.

Зөвлөмжийн биелэлтийг жилийн дүнгээр зөвлөмжийн тоогоор нь авч үзвэл 92.8 хувьтай, мөнгөн дүнгээр авч үзвэл 100 хувьтай гарч байна. Хэрэгжих хугацаа болсон 220 зөвлөмжийн биелэлтийг бүрэн хангуулж, хэрэгжих хугацаа болоогүй 17 зөвлөмж дараа онд шилжлээ.

Өмнөх оноос шилжиж ирсэн гүйцэтгэл аудитын 13, нийцлийн аудитын 5, бүгд 18 зөвлөмж, тайлант онд санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 192, гүйцэтгэлийн аудитаар өгсөн 8, нийцлийн аудитаар өгсөн 2 зөвлөмжийн биелэлтийг холбогдох байгууллагуудаас авч биелэлтээр тооцов.

2020 оны 4 дүгээр улиралд хийгдсэн Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар өгсөн 8, Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны хөрөнгийн зарцуулалтад хийсэн нийцлийн аудитаар өгсөн 9, бүгд 17 хэрэгжих хугацаа болоогүй зөвлөмж дараа онд шилжиж байна.

6.2. Төлбөрийн актын барагдалт:

Өмнөх оноос шилжиж ирсэн 95.3 сая төгрөгийн, тайлант онд тогтоосон 59.9 сая төгрөгийн, нийт 155.2 сая төгрөгийн төлбөрийн актыг статистик мэдээний бүртгэлд тусгаж, барагдалтад хяналт тавьж ажиллан, гүйцэтгэлээр нийтдээ 117.4 сая төгрөгийн актыг барагдуулж, 19.3 сая төгрөгийн актыг тэргүүлэх аудиторовн тушаалаар хүчингүй болгож бүртгэлээс хасав.

Төлбөрийн актын барагдалт нийт дүнгээр 87.6 хувьтай тайлагнагдаж байгаа боловч үүнээс өмнөх оноос шилжиж ирсэн актын барагдалт 91.1 хувьтай, тайлант оны актын барагдалт 82.6 хувьтай гарч байна. Санхүүгийн тайлангийн аудитын акт 95.3 хувьтай, гүйцэтгэлийн аудитын акт 80.0 хувьтай, нийцлийн аудитын акт 75.5 хувьтай байна. 18.8 сая төгрөгийн 9 төлбөрийн акт дараа онд шилжлээ.

Энэ нь өмнөх онд Иргэн, хуулийн этгээдэд гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнээс бусад зориулалтаар газар эзэмшүүлэх шийдвэр, үйл ажиллагаа хууль, тогтоомжид нийцсэн эсэх сэдвээр хийсэн нийцлийн аудитын төлбөрийн актаас 14.0 сая төгрөгийн, тайлант онд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар тавигдсан 4.5 сая төгрөгийн, гүйцэтгэлийн аудитаар тавигдсан 0.3 сая төгрөгийн, нийцлийн аудитаар тавигдсан 5.5 сая төгрөгийн, бүгд 18.8 сая төгрөгийн төлбөрийн акт байна.

Өмнөх онд газрын тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар тогтоосон төлбөрөөс зарим сумын иргэд, аж ахуйн нэгжүүд актын төлбөрийг барагдуулаагүй, газрыг ашиглахаас татгалзан тул сумын Засаг даргын захирамжаар газар эзэмшүүлсэн захирамжийг хүчингүй болгосон, хуучин эзэмшиж байсан газарт сунгалт хийхдээ шинээр олгосноор захирамж гаргаснаас акт тавигдсан г.м нөхцөл байдлыг тухайн сумуудын Засаг дарга нарын хүсэлт, холбогдох нотлох баримтуудыг үндэслэн төлбөрийн үлдэгдлийг тушаалаар хүчингүй болгож бүртгэлээс хаслаа.

Өмнөх оноос шилжиж ирсэн санхүүгийн тайлангийн аудитын 45.7 сая төгрөгийн актыг бүрэн барагдуулж, нийцлийн аудитын 49.6 сая төгрөгийн актаас

22.0 сая төгрөгийг барагдуулж, 19.1 сая төгрөгийн актыг тушаалаар хүчингүй болгосон.

Тайлант онд санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 50.7 сая төгрөгийн актаас 46.2 сая төгрөгийн, гүйцэтгэлийн аудитын 1.5 сая төгрөгийн актаас 1.2 сая төгрөгийн, нийцлийн аудитын 7.7 сая төгрөгийн актаас 2.2 сая төгрөгийн актыг барагдууллаа.

Тайлант онд төлбөрийн актын дүнгээр орон нутгийн төсөвт 104.8 сая төгрөгийг, Нийгмийн даатгалын сангийн дансанд 12.6 сая төгрөгийг, нийтдээ 117.4 сая төгрөгийг барагдуулж орууллаа.

6.3. Албан шаардлагын хэрэгжилт:

Өмнөх оноос шилжиж ирсэн 429.5 сая төгрөгийн, тайлант онд өгөгдсөн 14583.4 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлагыг статистик мэдээний бүртгэлд тусгаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллан, хэрэгжих хугацаа болсон албан шаардлагын хэрэгжилтийг холбогдох байгууллагуудаас авч баримтжуулав.

Санхүүгийн тайлангийн аудитын албан шаардлага 97.9 хувьтай, гүйцэтгэлийн аудитын албан шаардлага 71.7 хувьтай, нийцлийн аудитын албан шаардлага 25.6 хувьтай харагдаж байгаа боловч хэрэгжих хугацаа болсон албан шаардлагын хэрэгжилтийг 100.0 хувь хангууллаа. Өмнөх онд газрын тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар тогтоосон албан шаардлагын төлбөрөөс 7.1 сая төгрөгийг тушаалаар хүчингүй болгож бүртгэлээс хаслаа.

Өмнөх оноос шилжиж ирсэн нийцлийн аудитын 333.4 сая төгрөгийн албан шаардлагаас 189.2 сая төгрөгийн хэрэгжилтийг хангуулж, гүйцэтгэлийн аудитын 96.1 сая төгрөгийн албан шаардлагыг хуулийн байгууллагад шилжүүлсэн.

Тайлант онд санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2875.0 сая төгрөгийн албан шаардлагаас 2814.7 сая төгрөгийн, гүйцэтгэлийн аудитаар өгсөн 6421.8 сая төгрөгийн албан шаардлагаас 4667.0 сая төгрөгийн, нийцлийн аудитаар өгсөн 5286.6 сая төгрөгийн албан шаардлагаас 1242.6 сая төгрөгийн хэрэгжилтийг хангуулав.

Өмнөх оны 233.2 сая төгрөгийн 2, тайлант оны 5849.1 сая төгрөгийн хэрэгжих хугацаа болоогүй 17 албан шаардлага дараа онд шилжиж байна.

Энэ нь өмнөх онд Иргэн, хуулийн этгээдэд гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнээс бусад зориулалтаар газар эзэмшүүлэх шийдвэр, үйл ажиллагаа хууль, тогтоомжид нийцсэн эсэх сэдвээр хийсэн нийцлийн аудитаар өгсөн 137.1 сая төгрөгийн, тайлант оны санхүүгийн тайлангийн аудитын 60.3 сая төгрөгийн, Сум хөгжүүлэх санд хийсэн гүйцэтгэлийн аудитаар өгсөн 1743.9 сая төгрөгийн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хийсэн гүйцэтгэлийн аудитаар өгсөн 97.0 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтад хийсэн нийцлийн аудитаар өгсөн 4044.0 сая төгрөгийн хэрэгжих хугацаа болоогүй албан шаардлага байна.

Өмнөх оны 8.5 сая төгрөгийн төлбөрийн акт, 137.1 сая төгрөгийн албан шаардлагын хэрэгжих хугацааг Ковид-19 цар тахлын нөхцөл байдалтай

холбоотойгоор 2021 оны 7 дугаар сарын 01-ний хүртэл хугацаагаар сунгасан болно.

Тайлант онд албан шаардлагын дүнгээр орон нутгийн төсөвт 43.7 сая төгрөгийн орлого оруулав.

6.4. Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал:

Тайлант онд аудитын асуудалтай холбоотой хуулийн байгууллагад 3 удаа, Захиргааны хэргийн шүүхэд 2 удаа нэхэмжлэл гаргасан байна. Тухайлбал:

Өмнөх оноос шилжиж ирсэн Онцгой байдлын газрын бүртгэлд авагдаагүй 96.1 сая төгрөгийн орон сууцтай холбоотой асуудлыг шалгуулахаар Авлигатай тэмцэх газарт 2020 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 68 дугаар албан бичгээр шилжүүлсэн бөгөөд аймгийн Прокурорын газраас хянаж хэрэг бүртгэлийн хэрэг нээхээс татгалзсан хариу ирүүлсэн. Энэхүү асуудлаар аймгийн Ерөнхий прокурорт гомдол гаргасан боловч Прокурорын тогтоолоор хэрэг бүртгэлийн хэрэг нээхээс татгалзан шийдвэрлэсэн нь үндэслэлтэй гэж хүлээн авахаас татгалзан хариу ирүүлжээ.

Мөн аймгийн Прокурорт Баяннуур сумын Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сантай холбоотой 94.4 сая төгрөгийн 2 асуудлыг шалгуулахаар шилжүүлсэн бөгөөд аймгийн Прокурорын газрын прокурорын 2020 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн 5/76 дугаар тогтоолоор хэрэг бүртгэлийн хэрэг нээхээс татгалзсан байна.

Дээрх Онцгой байдлыг газрын 96.1 сая төгрөгийн орон сууцыг орлого авхуулах шийдвэр гаргуулах талаар Баян-Өлгий аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 2020 оны 10 дугаар сарын 05-ний өдрийн 641 тоот албан бичгээр нэхэмжлэл гаргасан бөгөөд шүүхээс нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан шийдвэр гаргасан. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд 10 дугаар сарын 19-ний өдөр 651 тоот албан бичгээр дэвж заалдах гомдол гаргасан ба шийдвэрлэсэн талаар хариу ирүүлээгүй байна. Үүнийг ТАБ-СМ-ЗВ маягтаар үлдэгдлээр гаргав.

Үүнээс гадна Баяннуур сумын Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх санд өргөдлийн дагуу хийсэн аудитаар 94.4 сая төгрөгийн зөрчлийг аймгийн Прокурорт шилжүүлсэн бөгөөд прокуророос хэрэг бүртгэлийн хэрэг нээхээс татгалзсан шийдвэр гаргасан байна.

Мөн аймгийн Прокурорт өмнөх онд шилжүүлсэн асуудлын шийдвэрлэлтийн талаарх 3 удаа албан бичгээр хандаж хариуг авсан болно.

Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны зарцуулалтад хийсэн нийцлийн аудитын дүнгээр Монгол улсын Ерөнхий аудиторт Өлгий сумын 8 дугаар цэцэрлэгийн 1208.0 сая төгрөгийн өртөгтэй барилгын тендер, Дэлүүн сумын “Нур” хувийн эмнэлэгт 20.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлсэн 2 асуудлыг шалгуулахаар саналаа хүргүүлсэн. Үүнийг ТАБ-СМ-ЗВ маягтаар үлдэгдлээр гаргав.

Тайлант онд хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудлын нэгдсэн бүртгэл хөтөлж, статистик мэдээнд тусган мэдээллийн санг баяжуулан ажиллаж байна. Мөн Үндэсний аудитын газрын Тамгын газраас ирүүлсэн чиглэлийн дагуу 2020 оны 9 дүгээр сард 2019-2020 онд хуулийн байгууллагад шилжүүлсэн асуудал болон Шүүхээр хянагдсан хэрэг маргааны судалгааг дэлгэрэнгүй байдлаар гаргаж хүргүүлсэн болно.

Долоо. Дотоод ажлын талаар.

6.1. Хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн талаар.

Тайлангийн хугацаанд батлагдсан үндсэн 11 орон тоо, гэрээт 1, бүгд 12 орон тоогоор ажиллалаа. Санхүүгийн тайлангийн аудитын үеэр ажлын ачааллыг харгалзан 3 гэрээт аудитор авч ажиллуулав. Мөн гэрээт ажилтнаар нэг хүнийг 5 сарын хугацаагаар авч ажиллууллаа.

Нийт 12 ажилтнаас дарга бөгөөд тэргүүлэх аудитор 1, аудитын менежер 1, ахлах аудитор 3, аудитор 8, жолооч 1, нягтлан бодогч, бичиг хэрэг хариуцсан гэрээт ажилтан 1 ажиллаж байна. Албан хаагч нарын 3 нь магистрийн зэрэгтэй, аудиторууд 100 хувь нь мэргэшсэн нягтлан бодогч байна.

Тус аудитын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн төрийн жинхэнэ албан хаагч бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг хийлгэж, хянаж батлан хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.

Албан хаагчдын хувийн хэргийн баяжилтыг шинэчлэн хийж, холбогдох материалуудыг журмын дагуу бүрдүүллээ. Хүний нөөцийн сарын мэдээг загвар маягтаар сар бүр гаргаж Хүний нөөцийн албанд тайлагнаж, ажилтнуудын талаарх судалгааг тухай бүр хүргүүлж ажиллалаа.

Ажилтнуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг улирлаар гаргуулан авч, дүнг Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж ажиллав.

6.2. Архив-албан хэрэг хөтлөлтийн талаар.

Байгууллагын албан хэрэг хөтлөлтийг хууль тогтоомж, зааварт нийцүүлэн гүйцэтгэж, ирсэн, явсан албан бичгийн бүртгэлийн дэвтрийг тус тусдаа бүртгэж тухай бүрд нь цохогдсон албан тушаалтанд танилцуулан, шийдвэрлэлтэд бүртгэлээр хяналт тавьж, хариутай албан бичгүүдийн хариуг хугацаанд хүргүүлж ажиллав.

Тайлант онд гаднаас нийт 829 албан бичиг хүлээн авч бүртгэлд тусгасны 48 нь УАГ-аас, 781 нь бусад байгууллагаас ирсэн байна. Үүнээс хариутай албан бичиг 235 байгаагийн 28 нь УАГ-аас, 207 нь бусад байгууллагаас иржээ. УАГ-аас албаны мейл 110 ирсний 28 нь албан бичиг, 54 нь судалгаа, санал ирүүлэх тухай, 28 нь дотоод мэдээллийн санд тавигдсан байна. Байгууллагаас гадагш чиглэсэн 727 албан бичиг гаргасны 40 нь УАГ-т, 687 нь бусад байгууллагад хандсан байна. Үүнээс хариутай албан бичиг 191 байна. Байгууллагад ирсэн болон гарсан албан бичгийг Able программд цахимаар оруулж цахим сан үүсгэж ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд Удирдлагын зөвлөлийн хурал 15 удаа, өглөөний шуурхай хурал 27 удаа, аудитын ажлын явцын талаар 7 удаа, бусад асуудлаар 2 удаа хурал хийж хурлын тэмдэглэлийг хөтөлж баримтжуулж ажиллав.

Тайлант онд хийгдсэн аудитын дүнгээр санхүүгийн тайлангийн аудитын 155 дүгнэлт, сонгуульд оролцох нам, нэр дэвшигчдийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт 116 дүгнэлт, бүгд 271 дүгнэлт гаргасан байна. Мөн аудитын дүнгээр илэрсэн зөрчилд 40 төлбөрийн акт тогтоож, зөрчил арилгуулах 104 албан шаардлага, сахилгын шийтгэл ногдуулах 13 албан шаардлага өгөгдсөн байна. Тэргүүлэх аудиторовын 32 тушаал гаргаж, 5 гэрээ хийгдсэн байна.

Дээрх бичиг баримтуудыг Монгол Улсын хууль, тогтоомж, холбогдох заавар журамд нийцүүлэн гаргаж, хууль зүйн үндэслэлийг хянаж, албан хэрэг хөтлөлт, архивын холбогдох журам, зааврын дагуу бүртгэлийн журналыг тус тусдаа бүртгэж хөтлөн баримтжуулан ажиллав. Байгууллагаас гарч байгаа албан бичиг, дүгнэлт, төлбөрийн акт, албан шаардлага, тушаал шийдвэрийн төслийг хоёр шатны хяналтаар тухай бүр хянаж, заавар зөвлөгөө өгч ажиллаж байна.

Тайлант онд хийгдсэн санхүүгийн тайлангийн аудитын 168, гүйцэтгэлийн аудитын 42, нийцлийн аудитын 24, бусад тайлан мэдээ 10, нийт 244 архивын баримт бичгийг архивын хууль тогтоомжийн дагуу баримт хадгаламжийн нэгжийг ажилтнуудаас хүлээн авч үдэж архивлан, байгууллагын архивт шилжүүлэв. Байгууллагын архивын бичиг баримтын хадгалалтад үзлэг хийж, эмх цэгцийг сайжруулав. Тус газарт нь архивын зориулалтын өрөөгүй бөгөөд аймгийн ЗДТГ-аас өгсөн нэг давхрын хуучин ашиглалтгүй болсон 1.5*2 харьцаатай 3 кв.м-ын жижиг өрөөнд архивын баримт материалыг хадгалж байна. Архивын өрөөний багтаамж хүрэлцэхгүй байгаагаас зарим баримт материалыг аудитын менежерийн болон нууцын ажилтны өрөөний хананы шүүгээнд хадгалж байна. Мөн архивын өрөөнд багтахгүй болсноос олон жил болсон баримт материалын заримыг гараажид хадгалж байгаа болно. Аймгийн ЗДТГ-т зориулалтын архивын өрөө олгож өгөх талаар удаа дараа хүсэлт тавьж байгаа боловч одоогоор шийдэгдээгүй байна. 2021 онд зориулалтын архивын өрөөтэй болгож өгөхөөр амлалт өгч байна.

Төрийн аудитын газрын гүйцэтгэх 10 ажилтан, гэрээгээр санхүүгийн тайлангийн аудит хийсэн 2 ажилтнаас төрийн болон албаны нууц задруулахгүй байх баталгааг гаргуулан авч баримтжуулсан. Нууц баримт бичиг, бусад тээгчийг хадгалах зориулалтын өрөө бий болгож, цонхонд нь хамгаалалтын төмөр тор хийлгэж, нууц баримт бичгийг зориулалтын сейфт хадгалж, цаасаар авсан баримт бичгийг нууцлан хадгалж, файлаар авсан баримтыг нууцын компьютерт нууц үгтэй сейфт хадгалж байна.

Аймгийн Тагнуулын газарт 2019 онд төрийн болон албаны нууцтай холбоотой хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг хуулийн дагуу 1 дүгээр улиралд хүргүүлсэн. ТАБ-ын төрийн болон албаны нууц хамгаалалт, бүртгэл хөтлөлт, архивын хадгалалт, хамгаалалтыг холбогдох хууль, тогтоомж, журам зааврын хүрээнд хэрэгжүүлэн ажиллав.

Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан Хилийн цэрэг, Зэвсэгт хүчний ангиудын 2019 оны санхүүгийн тайланг нууцлалтай хүлээн авч, хариуцсан

аудиторуудад шилжүүлж, аудит дууссаны дараа аудитын тайлангийн ажлын баримтуудыг нэгжилт хийлгэж аудитын дүгнэлт, тайлан, холбогдох санхүүгийн баримтуудыг нууцлан хүлээн авч, бүртгэж, аудиттай холбоотой файлаар мэдээллийг нууцын компьютерт, ажлын баримтыг архивын нэгж үүсгэн нууцын сейфт зохих журмын дагуу хадгалж байна. Аймаг дахь Тагнуулын газрын төлөвлөгөөт шалгалтаар нууцлалтай холбоотой нууцын ажлыг шалгуулж хангалттай гэсэн үнэлгээтэй ажлаа дүгнүүлж, шалгалтаар өгсөн заавар зөвлөмжийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна.

6.3. Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн талаар.

Тайлангийн хугацаанд тус газар нь байгууллага, иргэдээс нийт 15 өргөдөл, хүсэлт хүлээн авч үүнээс 11 өргөдөл, хүсэлтийг хугацаандаа шалган шийдвэрлэж хариу өгсөн болно. Харин 4 өргөдлийг харьяаллын дагуу холбогдох байгууллагуудад шилжүүлсэн.

ҮАГ-аас манайд харьяаллын дагуу шилжүүлсэн 2 өргөдлийг шалгаж хариуг өргөдөл гаргагч нарт болон ҮАГ-т хүргүүлсэн. Шалгалтын дүнгээр 107.4 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага өгч, 0.4 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, биелэлтийг хугацаанд авч зөрчлийг арилгуулав. Мөн 1 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлж биелэлтийг хангуулж, 1 асуудлыг хуулийн байгууллагаар шалгуулахаар шилжүүлсэн болно. Албан шаардлага, төлбөрийн акт, хариуцлага тооцуулах саналын хэрэгжилтийг бүрэн хангуулж, биелэлтийг холбогдох байгууллагуудаас авч баримтжуулав.

6.4. Мэдээллийн ил тод байдал, олон нийттэй харилцах ажлын талаар

Төрийн аудитын үйл ажиллагааг олон нийтэд ил тод, нээлттэй, шударга байлгах үүднээс аудитыг эхлэх бүр аудитын нээлт хийж, аймгийн болон тухайн байгууллагуудын удирдлагуудад мэдээлэл өгч, аудитын зорилгыг танилцуулж ажиллав.

Үндэсний аудитын газрын audit.mn вэб сайтад аймгийн Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, аймгийн нэгдсэн төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн тайлангийн аудитаар санал дүгнэлт гаргасан байгууллагуудын аудитын тайлан, гүйцэтгэлийн болон нийцлийн аудитын тайлангуудыг тус тус байршуулж, аудиттай холбоотой 2 зарлал байршууллаа.

Аймгийн Олон нийтийн орон нутгийн радиогоор казах хэл дээр 18 удаа аудитын дүнгийн талаар болон бусад мэдээлэл нэвтрүүлэг хийж, байгууллагын мэдээллийн самбарт аудитын дүн, цаг үеийн ажлын талаар 12 төрлийн мэдээ, мэдээлэл бэлтгэж байршуулж ажиллав.

Төсвийн төлөвлөлт, зарцуулалттай холбоотой бусад мэдээллийг хуулийн хугацаанд нь shilendans.gov.mn нэгдсэн цахим хуудсанд байршуулж мэдээлж байна.

6.5. Төрийн албан хаагч нарын мэдлэг, чадварыг дээшлүүлэх сургалтын талаар.

Төрийн аудитын байгууллагын 2020 оны сургалтын чиглэл, ерөнхий төлөвлөгөө, Төрийн аудитын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн байгууллагын 2020 оны дотоод сургалтын төлөвлөгөөг боловсруулан, тэргүүлэх аудиторын тушаалаар баталж, хэрэгжилтийг ханган ажиллав.

Дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу санхүүгийн тайлангийн аудитын чиглэлээр хийх танхимын сургалтыг 2020 оны 01 дүгээр сарын 15-17, 11 дүгээр сарын 02-04-ний өдрүүдэд зохион явуулав. Сургалтад тус газрын аудиторууд болон гэрээт аудиторууд хамрагдаж, өмнөх онд хийсэн аудитын дүн, цаашид анхаарах асуудал, 2020 оны санхүүгийн тайланд хийх аудитын хуваарь, төлөвлөгөөний талаар ярилцаж, Төрийн аудитын байгууллагаас 2020 онд хийх санхүүгийн тайлангийн аудитын бодлого, ерөнхий чиглэл, анхаарах асуудлууд, санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой хууль, журам, заавар, аудитын олон улсын стандарт, СТАУС программ, гүйцэтгэлийн болон нийцлийн аудиттай холбоотой сэдвүүдээр сургалт хийсэн болно.

Ковид-19 цар тахлын хязгаарлалттай холбоотой 6 дугаар сард хийх сургалтыг байгууллага дотор цахим хэлбэрээр зохион байгуулав. Ажилтнууд УИХ-аас шинэчлэн батлагдаж 2020 оны 6 дугаар сарын 01-нээс мөрдөгдөж байгаа Төрийн аудитын тухай хууль, Төрийн аудитын MNS 6817:2020 стандартыг бие дааж судалж байна.

Байгууллагын дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу Монгол Улсын Ерөнхий аудиторын 2013 оны 181 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас төрийн болон байгууллага хувь хүний нууцад хамрагдах асуудалтай танилцах, аудит хийх, нууцлах журам” сэдэвтэй сургалт явуулж, нууцын байгууллагад шалгалт хийсэн аудиторуудыг тухай бүрд арга зүйгээр хангаж ажиллав.

Нягтлан бодогч Х.Гүлбану, аудитор Ж.Назгүл, Х.Еркебулан нар ММНБИ-ээс зохион байгуулсан мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох, эрх сунгах онлайн сургалтад хамрагдаж, шалгалтыг онлайн хэлбэрээр өгч аудитор Р.Баярмаа ММНБИ-ээс зохион байгуулсан мэргэшсэн нягтлан бодогчийн онлайн сургалтад бие дааж хамрагдлаа.

Үндэсний аудитын газраас Удирдлагын академитай хамтран 5 дугаар сард зохион байгуулсан ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц зайн онлайн сургалтад ахлах аудитор М.Айнур, Х.Манаргүл, Д.Назгүл нар хамрагдаж шалгалтаа амжилттай өгч тэнцлээ. Тэргүүлэх аудитор 2 удаа удирдах ажилтны зөвлөгөөн семинарт оролцсон.

Мөн Үндэсний аудитын газраас зохион байгуулсан "Хуулийн хэрэглээ" цахим сургалтад 8 дугаар сард 2 ажилтан, 10 дугаар сард 9 ажилтан бүрэн хамрагдаж, шалгалт өгч амжилттай дүн үзүүлэв.

6.6. Ажилдаа нэвтрүүлсэн тэргүүн туршлага, шилдэг арга барил, шинэ санаа.

Өмнөх жилүүдэд ТШЗ-ийн СТА-ын төлөвлөгөөг тайлан ирсэн тухайн үед хийж байсан бөгөөд СТА-д цаг хугацаа их зарцуулж ТШЗ-ийн СТА хуулийн хугацаанд дуусдаггүй байсан. Энэ жилээс ТШЗ-ийн СТА-ын төлөвлөгөөг санхүүгийн тайлан ирэхээс өмнө буюу 1-р сарын 20-ны дотор хийж СТАУС программд оруулж дуусгахаар аудиторруудад ажлын төлөвлөгөө гаргаж өгч биелэлтэд хяналт тавьж ажиллалаа. Үүний үр дүнд бүх аудиторрууд ТШЗ-ийн санхүүгийн тайлан ирэхээс өмнө төлөвлөгөөг хийж дуусган СТАУС программд оруулж авснаар ТШЗ-ийн СТА-ыг хуулийн хугацаанд дуусгасан.

Ажилчдын эрүүл мэнд, дархлааг дэмжиж, коронавирусаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэн Санхүүгийн тайлангийн аудитын ажлын ачааллын үед 2 сарын турш нийт ажилтнуудад өдөрт 1 удаа аарц, нэг удаа чацарганы шүүс өгөх ажлыг санаачлан хэрэгжүүлж ажиллалаа. Энэхүү арга хэмжээг авч хэрэгжүүлснээр ажилтнуудын эрүүл мэнд, дархлааг сайжруулахад зохих үр дүн өгч, эрүүл мэндийн шалтгаанаар эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн хүн байхгүй бөгөөд үр дүнд төлөвлөгөөт аудитруудыг хугацаанд хийж дуусгасан болно.

Монгол Улсад ковид-19 вирус дотоодод тархаж, бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэн үед ажилтнуудыг коронавирусний халдвараас хамгаалах үүднээс хэмнэлттэй байгаа төсвийн хөрөнгөөр ажилтнуудыг амны маск, нэг удаагийн бээлийгээр, өрөө бүхнийг гар ариутгагчаар шингэнээр хангаж, албан өрөө бүрийн хаалганд “Та масктай үйлчлүүлнэ үү, танд онцын шаардлагагүй бол орохгүй байхыг хүсье” гэж бичсэн хуудсыг нааж байршууллаа. Энэ нь ажилтнуудыг болзошгүй халдвараас урьдчилан сэргийлсэн үр дүнтэй арга хэмжээ болсон бөгөөд гаднаас онцын шаардлагагүй хүмүүс орж ирэх нь эрс багасав.

Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-өөр Сум дундын ойн ангиас 5 дугаар сарын 16, 10 дугаар сарын 10-ны өдрүүдэд зохион байгуулсан мод тарих өдөрлөгт бүх ажилтнуудыг хамруулж, хуваарьт газарт модоо тарьснаас гадна өөрсдийн санаачилгаар онгоцны буудал явах зам дагуу байрлах мод үржүүлгийн газарт нийт 20 ширхэг, “СУАТ” ХХК-ны хашаанд 20 ширхэг мод тарьж Сум дундын ойн ангид хүлээлгэн өгөв. Энэ нь аймгийн ойжуулах ажилд хувь нэмрээ оруулсан үр дүнтэй арга хэмжээ болсон.

Хэвлэл мэдээлэл хариуцсан ажилтан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, гүйцэтгэлийн аудитын болон нийцлийн аудитын бүх тайлангуудыг товчилж аймгийн орон нутгийн радиогоор нэвтрүүлж байна. Орон нутгийн радиод өгсөн материалын нэг хувийг хүлээж авсан хүний гарын үсгийг зуруулж тусгай хавтаст хадгалан бүртгэл хийж, статистик мэдээ гаргаж байна.

Аймгийн орон нутгийн сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчдийг мэдээллээр хангах зорилгоор аймаг сумын ИТХ-ын сонгуулийн дараа нам, нэр дэвшигчдийг хуульд заасан хугацаанд сонгуулийн зардлын тайлангаа хувийн аудитын компаниар дүгнэлт гаргуулан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх, тайлангаа ирүүлээгүй бол Зөрчлийн тухай хуулийн дагуу захиргааны хариуцлага хүлээлгэх хуулийн зохицуулалттай тухай албан бичгийг намын

хороодод хүргүүлж, энэ тухай зарлалыг байгууллагын вэб сайтад байршуулав. Мөн орон нутгийн өдөр тутмын радиогоор 5 удаа зарлал өгч, “Баян-Өлгий зар мэдээ” гэсэн фейсбүүк хуудсанд байршуулав. Энэ нь тус аймагт орон нутгийн сонгуульд оролцсон намын хороод болон нэр дэвшигчдийг сонгуулийн зардлын тайландаа дүгнэлт гаргуулан төрийн аудитын газарт ирүүлэх тухай мэдээллээр хангасан чухал ач холбогдолтой арга хэмжээ болсон. Яагаад гэвэл ялангуяа сумын ИТХ-д нэр дэвшигч нарын ихэнх нь энэ талаар ямар ч хуулийн мэдлэггүй байсан. Үүний үр дүнд 21 намын хороо, 758 нэр дэвшигч хуулийн хугацаанд тайлангаа ирүүлсэн байна.

6.7. Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд.

Тус Төрийн аудитын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төрийн аудитын байгууллагын “Нийгмийн хамгааллын хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах төлөвлөгөөг гаргаж хэрэгжүүлэн ажиллав.

Төлөвлөгөөний дагуу албан хаагчдын ажлын байрны ая тухтай байдал, ажиллах орчныг сайжруулж ажиллах нөхцөл бололцоогоор хангах зорилгоор бүх өрөөнүүдэд халаалтын тенг, ус буцалгагч, агаар чийгшүүлэгчтэй болгов.

Албан хаагчдын үндсэн цалин болон нэмэгдлийн хэмжээг жилийн эхэнд хууль, журмын дагуу шинэчлэн тогтоож, цалин хөлсийг сар бүрийн 20-25-ны хооронд олгож байна.

Олон Улсын эмэгтэйчүүдийн баяраар эмэгтэй албан хаагч нарт нийт 250.0 мянган төгрөгийн, эх хүүхдийн баяраар албан хаагч нарын хүүхдүүдэд 200.0 мянган төгрөгийн гарын бэлэг олгов.

Төрсөн эцэг нь нас барсан аудитор Х.Еркебуланд байгууллагаас 200,0 мянган төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлэв.

Төрийн алба болон төрийн аудитын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажилласан дарга бөгөөд тэргүүлэх аудитор М.Хуанганыг “Алтан гадас” одонгоор шагнуулахаар, аудитор Б.Үүрийнтуяаг “Төрийн хяналтын тэргүүний ажилтан” цол, тэмдгээр шагнуулахаар хамт олны хурлаар хэлэлцүүлж холбогдох материалыг Үндэсний аудитын газарт хүргүүлэв.

Албан хаагчдад орон сууц худалдан авахад дэмжлэг үзүүлэх зорилгоор хамт олны хурлын шийдвэрийн дагуу 1 хүнд 10.0 сая төгрөг олгохоор нэмэлт санхүүжилтээр эх үүсвэрийг шийдвэрлүүлэхээр Монгол Улсын Ерөнхий аудиторт холбогдох материалыг хүргүүлж шийдвэрлүүлээ.

Долоо. Санхүүгийн тайлагнал, төсвийн гүйцэтгэлийн талаар.

Тус газрын нягтлан бодох бүртгэлийн дансанд 2020 оны хагас жилийн байдлаар үндсэн хөрөнгө 225.1 сая төгрөгийн, бараа материал 6.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй, Төрийн сан дахь төсвийн харилцах данс болон нэмэлт санхүүжилтийн харилцах дансыг жилийн эцэст үлдэгдэлгүй гаргахаар төлөвлөж байна. Жилийн эцсийн санхүүгийн тайлан эцэслэн гараагүй учраас санхүүгийн бусад үзүүлэлтүүдийн талаар бичих боломжгүй байна.

Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг хийж, тооцоог бодож, актлах үндсэн хөрөнгийн жагсаалтыг гаргаж байгууллагын Өмч хамгаалах зөвлөлийн хурлаар хэлэлцэж, ТӨБЗГ-аас зөвшөөрөл авч өгөх тухай албан бичгийг Үндэсний Аудитын газарт холбогдох материалуудын хамт хүргүүлсэн.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын 2020 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/131 дугаар албан бичгээр 3424.9 мянган төгрөгийн ашиглах хугацаа нь дуусаж, элэгдлийг бүрэн нөхсөн, цаашид ашиглах боломжгүй болсон үндсэн хөрөнгийг акталж данснаас хасах зөвшөөрөл ирүүлсний дагуу 6 нэр төрлийн 3424.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, устган, данс бүртгэлээс хасав.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 10 дугаар сарын 08-ний өдрийн 484 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж тус газрын үндсэн хөрөнгө дансанд бүртгэлтэй байсан Ланд-80 автомашиныг дуудлага худалдаа зохион байгуулан худалдаж, орсон орлогыг улсын төсөвт оруулж, байгууллагын нэрээс хасалт хийлгэж, хөрөнгийн хөдлөлийг хууль журмын дагуу нягтлан бодох бүртгэлд тусгалаа.

2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд “Грант Торнтон Аудит” ХХК-иар санхүүгийн тайлангийн аудит хийлгэж “Зөрчилгүй санал дүгнэлт” авсан. Аудитаар өгсөн зөвлөмжүүдийг бүрэн хэрэгжүүлж, биелэлтийг Үндэсний аудитын газарт хугацаанд хүргүүлж ажиллав.

Тус газрын 2020 оны жилийн үйл ажиллагаанд 447,8 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр улсын төсвөөс 447,8 сая төгрөгийн санхүүжилт авч, 447,8 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулав.

Төсвийн гүйцэтгэлийг зардлын зүйл ангиар авч үзвэл: цалингийн зардалд 356,8 сая төгрөгийг, НДШ-д 49,2 сая төгрөгийг, бичиг хэргийн зардалд 3,5 сая төгрөгийг, шуудан холбооны зардалд 1,4 сая төгрөгийг, тээвэр шатахууны зардалд 7,2 сая төгрөгийг, дотоод томилолтын зардалд 7,5 сая төгрөгийг, зочин төлөөлөгч хүлээн авах зардалд 1,0 сая төгрөгийг, бага үнэтэй түргэн элэгдэх зүйл худалдан авахад 0.1 сая төгрөгийг, хичээл дадлага, үйлдвэрлэлийн зардалд 2,5 сая төгрөгийг, гэрээт ажиллагсдын зардалд 10,9 сая төгрөгийг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжид 7,8 сая төгрөгийг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд 1,0 сая төгрөгийг тус тус зарцуулав.

Найм. Дүгнэлт, санал.

Тайлангийн хугацаанд Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газар нь Монгол Улсын Төрийн аудитын тухай хууль болон бусад хууль тогтоомжийг удирдлага болгон аудитын олон улсын стандартын хүрээнд үйл ажиллагаагаа явууллаа.

1. Санхүүгийн тайлангийн аудитын хугацаанд нэгдсэн удирдамжаар хийсэн 2 гүйцэтгэл, нийцлийн аудит давхцаж хийгдсэн нь ажлын ачааллыг маш их нэмэгдүүллээ.

Цаашид аймаг дахь Төрийн аудитын газрын орон тоог нэмж, аудитын чиглэлээр төрөлжүүлэн ажиллуулах шаардлагатай байна.

2.Байгууллагын 2020 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг СУГ-т МУЕА-ын 2020 оны А/20 дугаар тушаалын хавсралтаар баталсан загвар маягтаар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газарт тус газраас ирүүлсэн загвар маягтаар гаргаж тайлагнаж байна. Ингэж Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг хоёр газарт хоёр өөр загвараар гаргаж тайлагнаж байгаа нь хүндрэлтэй байгаа тул цаашид Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг нэг загвараар гаргах талаар холбогдох журамд өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Ес. Хавсралтууд

Газрын 2019 оны үйл ажиллагааны тайланд дараах мэдээллийг хавсаргав.Үүнд:

ТАБ-СМ-1А, ТАБ-СМ-1Б, ТАБ-СМ-1В

ТАБ-СМ-2А, ТАБ-СТ-2Б, ТАБ-СТ-2В

ТАБ-СМ-3А, ТАБ-СМ-2Б, ТАБ-СМ-3В

ТАБ-СМ-4А, ТАБ-СМ-4Б, ТАБ-СМ-4В

ТАБ-СМ-5, ТАБ-СМ-6, ТАБ-СМ-8

Үр өгөөжийн тайлангийн нэгтгэл УАГ-1135 маягт, нотлох баримтууд

Төсвийн орлогын дансанд төвлөрүүлсэн орлогын жагсаалт

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

/М.ХУАНГАН/

ТАЙЛАНГ БОЛОВСРУУЛСАН:

МЕНЕЖЕР

/Х.ЖЕНИСБЕК/